

ИММОРАЛИЗМД ЭЕРГЭЭР ХАНДАХ НЬ

М.Золзаяа. Доктор /Ph.D/

Түлхүүр үг: *immoralism, nihilism, umoralism*

Имморализм нь латин хэлний *immoralis*-ёс суртахууны бус гэсэн утгатай үг. Имморализм нь 1/ ёс суртахууны талаас ярьдаггүй, 2/ ёс хэрэглэгдсээр иржээ. Имморализмд эергээр хандах нь олон талын ач холбогдолтой мэт санагдана. Үүнийг зүй бусын, ёс горимгүй гэдэгтэй шууд адилтгаж боломгүй. Имморализм нь ёс суртахууныг үгүйсгэхүйд үндэслэх агаад ёс суртахуунлаг үйлдлийн эхлэл болох нь ч бий. Иймээс ёс суртахууны ухамсарт имморализмын гүйцэтгэх үүргийг орхигдуулахгүй байх нь зөв сонголт, шийдвэр гаргахад тус дөхөм болно.

Ёс зүйн түүхэнд имморализмын тухай эртнээс тэмдэглэжээ. Грекийн философич Гераклит "Орчлонгийн зайлшгүй хуулийг логос гэнэ. Логосын цаг үргэлж логостой тулгарах боловч түүнийг ухаардаггүй" гэж үзсэн нь имморализмыг шууд бишээр илэрхийлж байна. Ёс суртахууны хэм хэмжээнд шүүмжлэлтэй хандсан чиглэл нь софизм болно. Софист Горгий хууль бол хүний *тиран*, хувь хүн ба амьдралыг хүчирхийлдэг гэжээ. Хожмын софистууд хүний хүсэл зоригийг хязгаарлахгүйн тулд нийгмийн хэм хэмжээг бүгдийг устгах ёстой гэж үзжээ. Эллинизмын сүүл үеийн сургаалууд кинизм, стоик, эпикурчууд, скептик имморализмын утга агуулгыг зохих хэмжээнд илэрхийлжээ. Кинизмд "ёс суртахууны ерөнхий, түгээмэл дүрмийг зөвшөөрөөгүй. Жишээ нь, буянт үйл, зол жаргалыг туйлын баримтлах албагүй. Иргэншлийн үр шим болсон засгийн газар, хувийн өмч, гэрлэлт, шашин, тансаг амьдрал зэрэг нь бүгд утга учиргүй зохиомол цэнгэл болно. Тийм учраас цэнгэлээс зайлсхийж татгалзах нь ёс суртахууны үндэс" гэдэг юм. Харин Луций Анней Сенека "хүн нүгэл хийхээс өөрөөр байж чаддаггүй. Нүгэл хийснээр хүн хэвээр үлдэнэ харин нүгэл эс үйлдвэл мэргэн ухаантан болно" хэмээжээ. Стоицизмд "Сайн ба муу нь гагцхүү ёс суртахууны үнэлэмж. Аливаа үйлдэлд зөрчил үүсэх нь зайлшгүй иймээс сайн, муу ч байх зүйл" гэнэ.¹ Энэ бүхнээс үзвэл ёс суртахууны муугаас өөрийгөө засан сайжруулах, ухаарах боломж үүсэх ажээ.

Дорно дахины инь ян, арга билгийн үзэл сургаал нь дээрх санааг улам баяжуулна. Хан улсын үеийн философич Дүн Жүн-Шү "Хүн тэнгэрийн хуулбар учир оюун ухаанд хоёр элемент байдаг нь: син /ян/ буюу хүнлэг чанар буян төрүүлдэг, цин /инь/ буюу шунал нүглийг төрүүлдэг. Цин нь мэдрэл сэтгэлийн хөдөлгөөн, син хүний уг чанар."² Энэ үзэл нь мууг оюун ухааны салшгүй нэг тал гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Германы философич Г.В.Ф.Гегелийн *тезис, антитезис, синтез* гэсэн гурвалын зарчим хийгээд зөрчил бол хөдөлгөөн, хөгжлийн эх сурвалж. Ойлголт бүхэн дотоод зөрчилтэй байна хэмээх сургаал ч эл асуудалтай холбоотой. Мөн буддын

¹ А.А.Гусейнов, Г.Иррлитц. Краткая история этики. М.:Мысль, 1978.

² Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003.

философийн хоосон чанар, үйлийн үрийн тухай сургаал нь имморализмын агуулгатай байдаг. Тухайлбал, "Өчүүхэн бага буяны үрээс хэмжээлшгүй их амгалан гарах буюу өчүүхэн бага нүглийг бага гэж үзэж болдоггүй бөлгөө. Муу бүхний шалтгаан болсон нүглийг үйлдвээс түүний үр болсон зовлонг хэзээд эдлэнэ" хэмээдэг билээ.

Ёс суртахууны хэм хэмжээг чухалчлах нь имморализмыг төрүүлэх нэг нөхцөл. Энэ талаар Хятадын философич Жуан-з "тэнгэрийн доорхи ертөнцийг ямар байсан ба түүгээрээ байх боломж олгох хэрэгтэй. Байх боломж олгох хэрэгтэй гэдэг нь хүмүүсийн уг чанарыг удирдлагаар эвдэхээс болгоомжилсных. Удирдлага хүмүүсийн уг чанарыг хүчээр өөрчилж болно" гэжээ. Тэрээр ёс суртахууны зарчим, ёс горим, хуулийн хэм хэмжээ зэрэг нь хүний уг чанарыг эвдэхийг анхааруулжээ.

Имморализмд Германы философич Ф.Ницшегийн үзэл өндөр байр суурь эзэлдэг. Тэрбээр сайн, нигүүлсэл, хайр, номхон даруу гэдэг нь хувь хүнд тус болохгүй, харин эсрэгээр уян зөөлөн, дорой, идэвхигүй, хатуужилгүй, зориггүй болгоно гэж үзжээ. Мөн Ressentiment /өшөө хорсол/ нь эзэрхэх хүсэл зоригийн илэрхийлэл ба зовлон, мөхсөн амьдралыг үргэлжлүүлэх аскетик эрхэмлэлийн арга. Ressentiment нь өөрөө бүтээгч бөгөөд үнэт зүйл үүсгэдэг.² Ёс суртахуун нь үр дүн, шинж тэмдэг, баг, өвчин, тартюфст, эндүүрэл. Гэвч ёс суртахуун нь шалтгаан, хүч, хор, саад тогтор бас эм дом³ гэх зэргээр имморализмыг тодорхой үндэслэсэн.

Имморализм хүнийсгэл, ёс суртахуунгүй үзэгдэлтэй салшгүй холбоотой. Ёс суртахуунгүйгээс эх үндэстэй ёс суртахуунлаг үйлдэл илүү үр дүнтэй бат бэх байж болно. Ийм үндэслэгээг агуулсан хос ёсны сургаал Монголын мэргэдийн бүтээлд ч элбэг тохиолдоно. Тухайлбал, хортой ба тустай, мэдэл чадал төгс ба мэдэл багат мунхаг, сайн шударга ба саваагүй муу, өчүүхэн эрдэмтэн ба эрдэм төгс мэргэн, хөшүүн ба зөөлөн зан, ухаан муутан ба оюун төгөлдөр гэх мэтийн ялгаатай мөн чанар, үнэлэмжийг харьцуулан гэм эрдмийг ялгаж мэдээд сайн, мууд хос ёсны зарчмаар тэгш хандахыг үндэслэл болгосон байдаг.⁴

Ёс зүй ба сэтгэлзүйн үүднээс солиотой байдал нь имморализмын шинж болохыг Францын тайж Д.А.Ф.де Сад дэвшүүлснийг олон судлаачид тэмдэглэжээ. Сэтгэл зүйн солиотой явдал нь а/ ёс суртахууны зорилготой хуурмаг солиорол нь ихэрхэг зангаа засах аскетизм б/ шашны үнэн ёс суртахууны хууль хоёрын зөрчлийг харуулах талтай гэнэ. XX зууны 20-50 оны үед Д.А.Ф.де Садын "Будуарын философи" хэмээх текстэд:⁵ ёс суртахууны аффект нь буянт үйлийг ичгүүргүй солиотойгоор нуун далдлахын эсрэг байна. Өөрөөр хэлбэл туйлын буянт үйлийн өмнө бурхан солиотойгоор оршино" гэжээ.

Постмодернизмд нэгдсэн заавартай, туйлын түгээмэл үүрэгтэй сургаалууд нь "ямар нэг дэг журмыг эвдэх" нөхцлийг бүрдүүлдэг гэж үздэг. Бүхнийг бодит байдалдтай уялдуулан авч үзэх, ёс суртахууны тодорхой нэг хэм хэмжээнд өөрийгөө захируулах зэрэг нь хүний амьдралын үндэс,

¹ Мөн тэнд.

² Ф.Ницше. К генеалогии морали. М.,1997. с. 342

³ Там же. М.,1997. с. 306

⁴ М.Золзаяа. XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог. /Дисс/ УБ.,2007. 51 дэх тал.

⁵ Этика. Энциклопедический словарь. М.,2001. с.511

утга учрыг алдагдуулдаг. Мөн ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг үгүйсгэдэг ч огт хэм хэмжээгүй байх боломжгүйг зөвшөөрсөн юм¹ зарчим, ач холбогдлыг шууд үгүйсгэх нь түүхэн тодорхой цаг үе болон бие хүний үйлдлээ хянах чадварыг идэвхижүүлнэ.

Имморализмаас гадна нигилизм, дегуманизаци гэж ойлголтууд өргөн хэрэглэгддэг. Имморализмын илрэлийг нигилизм хуваалцана. Нигилизмын эх сурвалж нь пессимизм болно. Ф.Ницше нигилизмыг эмгэг, завсрын байдал гэж нэрлэсэн. Түүний үзлээр, нигилизм нь идэвхитэй, идэвхигүй гэж хоёр янз байна. Идэвхитэй нигилизм нь хүчирхийлэл, эвдэн сүйтгэх чиглэл бол идэвхигүй нигилизм нь эргэлзсэн, итгэлгүй, эцэж цуцсан байна. Идэвхитэй нигилизм нь ямар нэг үнэнийг танин мэдэхийг шаарддаг "эрх мэдэлд тэмүүлэхийн төрөл ба тусгай зэрэг дэвийн үнэ цэнэ"-ийг тодруулдаг.² Оросын философич Н.А.Бердяев "Нигилизм бүх соёлын бүрхүүлийг хуу татаж бүх түүхэн уламжлалыг эвдэх, хүнийг байгалиас чөлөөлөх, хоосон шаардлага" хэмээн бичсэн. Үүнээс үзвэл бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээ, үнэт зүйлийг бүрмөсөн үгүйсгэснийг ёс зүйн **нигилизм** гэдэг. Энэ нь зан байдлын сайн, муугийн тухай сургаалыг төдийлөн ойшоохгүйгээр үгүйсгэж байдаг. Нийгмийн амьдрал дахь хүмүүнлэг, ёс суртахууны болоод оюуны үнэлэмжээс татгалзах буюу түүнийг гээх, хүнийг үл хүндэлж, бие хүний шинж чанаруудыг үл тоомсорлохыг **дегуманизаци** гэнэ.

Түүнчлэн имморализм ба аморализмын ялгааг тогтоох ёстой. Энэ талаар судлаачид ихэвчлэн дараах тодорхойлолтыг баримталж байна. Аморализм эмпирик бодит байдалд илэрдэг. **Аморализм нь** ёс суртахууны үйлдлийн зан байдлын үгүйсгэдэг бөгөөд улмаар эмпирик эерэг үнэлэмж алдагдахын хорио болдог. **Имморализм нь** ёс суртахууны ухамсрын үгүйсгэл ба бодит байдлыг эзэмших өвөрмөц арга, улмаар нийгмийн харилцааг тогтворжуулах зарчим байдаг. Тухайлбал, имморализм ёс суртахуун, зан байдлыг тогтворжуулах тогтолцоо ба оршихуйд эргэлзэхэд хүргэдэг. Имморализмыг агуулгаар нь туйлын, харьцангуй гэж хоёр ангилж болох юм. Туйлын имморализм ёс суртахууныг тогтворжуулах зарчмыг гээдэг. Харьцангуй нь түүхэн тодорхой үеийн ёс суртахууны хэлбэрийг ухаарч шүүмжлэхэд хүргэдэг³ бөгөөд ёс суртахууны үнэлэмж цаг үеэ даган хувьсан өөрчлөгдөнө гэдэг.

Энэхүү имморализм нь ёс суртахууны ач холбогдол хийгээд ёс суртахуунгүйн нөлөөг тодруулна. Ёс суртахуунгүй орон зай нь имморализмын онтологи нөхцөл болдог байна. Имморализм нийгмийн практикт тогтсон хэм хэмжээг эвддэг ч тэнд үүссэн ёс суртахуунгүй байдлыг ямар нэг сайн сайхан зүйлд хүчээр тулгадаг. Нийгэмд имморализмын гүйцэтгэх эерэг үүрэг нь бүх нийтээр хүлээн зөвшөөрдөг үнэлэмж, үүргийн шалгуур болдогт оршино. Энэ нь янз бүрийн нөлөөлөлд бие хүн өөрийгөө

¹ Там же. с.371

² <http://www.ethics.ru>. 2007.11.21

³ Соловьева.Д.Е, "Имморализм в отечественной и зарубежной философии" /автореферат/. МГУ.,2007

зөв удирдахад нөлөөлнө. Үүний үр дүнд ёс суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн үйлдлээ харицлагатай гүйцэтгэх арга замыг нээж хэрэгжүүлэхэд хүргэдэг. Чухамдаа ёс суртахууныг үгүйсгэхийн зэрэгцээ хадгалж байх нь имморализмын онтологи үндэслэл юм.

Бид нийгмийн шилжилт, хямралын үед иммораль хүсэл илүүтэй илэрч байгааг нүдээр үзэж байна. Иммораль үзэгдэлд анализ хийж, түүний шалтгаан нөхцөл, үзэл суртлын хамаарлыг үнэн зөв тогтоож чадваас өнөөгийн ёс суртахууны доройтлыг оношлох нэг арга болоод зогсохгүй нийгмийн хөгжлийн чиг хандлагыг боловсронгуй болгоход ач холбогдолтой юм. Имморализм нь хүн соёлыг бүтээх, шинэчлэх үйл явцад илэрдэг үзэгдэл. Нөгөө талаар энэхүү сургаалыг олон нийтийн ёс зүйн боловсрол, хүмүүжлийн үйл ажиллагаанд өргөн сурталчлах нь олон сөрөг үр дагавар үүсгэж болохыг анхаарууштай. Өгүүлэн буй сэдэв их өргөн хүрээтэй ч, үүнд зөвхөн эергээр хандах оролдлогыг эхлэл төдий бичлээ.

Резюме

В истории философии имморализм представлен весьма широко. Имморализм является сложным, многогранным феномен. Имморалист принципиально отрицает мораль как в аксиологическом аспектах.

Ном зүй

1. А.А.Гусейнов, Г.Иррлитц. Краткая история этики. М.:Мысль, 1978
2. Соловьева.Д.Е, "Имморализм в отечественной и зарубежной философии" /автореферат/. МГУ.,2007
3. М.Золзаяа. XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог. /Дисс/ УБ.,2007.
4. Ф.Ницше. К генеалогии морали. М.,1997
5. Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003
6. Этика. Энциклопедический словарь. М.,2001
7. Ю.А.Щрейдер. Этика введение в предмет. М.,1998
8. Solomon, Robert C. Morality and the good life. N.Y. Graw-Hill, Inc.1992
9. <http://www.ethics.ru>. 2007.11.21